



156

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг тодорхойлох, урамшуулал олгох журам батлах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.6-д заасныг тус тус удирдлага болгон ТУШААХ нь:

1. Эмгэг судлалын үндэсний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох зорилгоор “Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг тодорхойлох, урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журам батлагдсантай холбогдуулан албадын дарга, тасаг, лабораторийн эхлэгч нар өөрийн харьяалах эмгэг судлаач эмч, эс судлаач, лабораторийн техникч, бусад ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, тодорхойлох, хамт ажлын хурлаар хэлэлцүүлж байхыг үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, төвийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг нэгтгэх, үнэлэх ажлыг зохион байгуулахыг Чанарын албаны дарга Э.Ундармаад даалгасугай.

ЗАХИРАЛ



Г.УЯНГА



**АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ
ТОДОРХОЙЛОХ, УРАМШУУЛАХ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн эмгэг судлаач эмч, эс судлаач, лабораторийн техникч, эрүүл мэндийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгээр улирлын мөнгөн урамшуулал олгох, гүйцэтгэлийн үнэлгээг үнэлж, тодорхойлох асуудлыг зохицуулахад оршино.

1.2. Улирлын ажлын үр дүнгээр улирлын мөнгөн урамшуулал олгохдоо төвийн албадын дарга, тасаг, лабораторийн эрхлэгч нар өөрийн харьяалах эмгэг судлаач эмч, эс судлаач, лабораторийн техникч, бусад эрүүл мэндийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, тодорхойлж, хамт олны хурлаар үнэлцүүлсэн байна.

1.3. Төвийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг нэгтгэх, нэгтгэх ажлыг Чанарын алба зохион байгуулна.

1.4. Энэхүү журмын 2.1-т заасан ажлын үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээ, шаардлага хангасан ажилтанд журмын 2.2-т заасан хувь хэмжээгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно.

1.5. Ажилтнуудын улирлын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг дараа ажлын эхний сарын 15-ны дотор үнэлж, төвийн захирлын тушаалаар олгоно.

**Хоёр. Ажлын үр дүн, гүйцэтгэлийн
шалгуур үзүүлэлт, үнэлгээ**

2.1. Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг тодорхойлж, үнэлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийнэ:

Албан тушаал	Үр дүнгийн үндсэн шалгуур үзүүлэлт	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Хувь/оноо
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт			50%
Эрүүл мэндийн ажилтан	Үйлчилгээний чанар	Ёс зүй, харьцааны байдал;	10%
	Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт;	10%
		Ажлын ачаалал;	10%
		Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал.	10%
Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал.	10%	
Б.Тусгай шалгуур үзүүлэлт			50%
Эмнэлгийн үйлчилгээний ажилтан	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар	Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал;	10%
		Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал;	10%
		Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол;	10%
		Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар.	10%
		Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт.	10%
Эрүүл мэндийн тусгай ажилтан	Хариуцсан ажлын чанар	Журам мөрдөж байгаа байдал;	10%
		Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар;	30%
		Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт.	10%
Нийт авбал зохих хувь/оноо			100%

21.1. Ажилтны ажлын цаг ашиглалтыг дараах аргачлалаар тооцон үнэлгээ

- Улиралд 120 минут хоцорсон бол -2 хувь;

